

## ЛИФТИЙН ЭВДРЭЛ ЗАСАХ АРГА ЗАМ ХИЧЭЭЛИЙН ТЕСТЫН АСУУЛТУУД

**1. Аливаа техникийн эвдрэл 4 шалтгаантай байдаг. Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Түүнийг буруу ажиллуулснаас эсвэл гадны нөлөөллөөс
2. Бүх техникт ашиглалтын явцад техникийн үйлчилгээ хийж байх шаардлагатай байдаг. Үүнийг хийхгүйгээс буюу чанаргүй хийснээс болоод
3. Ашиглагч байгууллагын удирдлага мэргэжлийн бус хүн учраас
4. Тухайн төхөөрөмж удаан хугацаагаар зөв ашиглагдсан боловч жам ёсоороо элэгдэж эвдрэх
5. Лифтэнд техникийн үйлчилгээ хийж байгаа хүний чадвар, туршлага муу, хариуцлагагүй, хайнга ажиллагаанаас мөн хийлгүүлж байгаа байгууллагын хяналт муугаас болж ажлынхаа явцад эд ангийг эвдэх, цахилгаан хэрэгслийг шатаах

Хариу 3

**2. Аливаа техникийн эвдрэл 4 шалтгаантай байдаг. Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Түүнийг буруу ажиллуулснаас эсвэл гадны нөлөөллөөс
2. Лифтчин мэргэжлийн бус учраас
3. Бүх техникт ашиглалтын явцад техникийн үйлчилгээ хийж байх шаардлагатай байдаг. Үүнийг хийхгүйгээс буюу чанаргүй хийснээс болоод
4. Тухайн төхөөрөмж удаан хугацаагаар зөв ашиглагдсан боловч жам ёсоороо элэгдэж эвдрэх
5. Лифтэнд техникийн үйлчилгээ хийж байгаа хүний чадвар, туршлага муу, хариуцлагагүй, хайнга ажиллагаанаас мөн хийлгүүлж байгаа байгууллагын хяналт муугаас болж ажлынхаа явцад эд ангийг эвдлэх, цахилгаан хэрэгслийг шатаах

Хариу 2

**3. Аливаа техникийн эвдрэл 4 шалтгаантай байдаг. Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Түүнийг буруу ажиллуулснаас эсвэл гадны нөлөөллөөс
2. Бүх техникт ашиглалтын явцад техникийн үйлчилгээ хийж байх шаардлагатай байдаг. Үүнийг хийхгүйгээс буюу чанаргүй хийснээс болоод
3. Тухайн төхөөрөмж удаан хугацаагаар зөв ашиглагдсан боловч жам ёсоороо элэгдэж эвдрэх
4. Лифтээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй учраас
5. Лифтэнд техникийн үйлчилгээ хийж байгаа хүний чадвар, туршлага муу, хариуцлагагүй, хайнга ажиллагаанаас мөн хийлгүүлж байгаа байгууллагын хяналт муугаас болж ажлынхаа явцад эд ангийг эвдлэх, цахилгаан хэрэгслийг шатаах

Хариу 4

**4. Лифтэнд эвдрэл нь түүний ажиллагаа гацах байдлаар илэрнэ. Энэ гацаа нь дараах шалтгаантай байна: Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Лифтийг бүхэлд нь угсрах үедээ түүний тавигдах хэмжээний зөвшөөрөгдөх алдааг хэтрүүлснээс

2. Тохируулах зай завсрыг тохируулахгүй элэгдсэн эд ангийг солиогүйгээс
3. Бэхэлгээний болтууд сул байх
4. Лифтийн бүрэн бүтэн байдлыг хариуцагчийг томилоогүйгээс
5. Лифтийг цэвэрлээгүй бохир байлгаснаас
6. Цахилгааны хүчдэл тасрах

Хариу 4

**5. Лифтэнд, эвдрэл нь түүний ажиллагаа гацах байдлаар илэрнэ. Энэ гацаа нь дараах шалтгаантай байна: Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Лифтийг бүхэлд нь угсрах үедээ түүний тавигдах хэмжээний зөвшөөрөгдөх алдааг хэтрүүлснээс
2. Лифтчин ажлаа тасалснаас
3. Тохируулах зай завсрыг тохируулахгүй элэгдсэн эд ангийг солиогүйгээс
4. Бэхэлгээний болтууд сул байх
5. Лифтийг цэвэрлээгүй бохир байлгаснаас
6. Цахилааны хүчдэл тасрах

Хариу 2

**6. Лифтэнд эвдрэл нь түүний ажиллагаа гацах байдлаар илэрнэ. Энэ гацаа нь дараах шалтгаантай байна: Энд ямар шалтгааныг илүү бичсэн байна вэ?**

1. Лифтийг бүхэлд нь угсрах үедээ түүний тавигдах хэмжээний зөвшөөрөгдөх алдааг хэтрүүлснээс
2. Тохируулах зай завсрыг тохируулахгүй элэгдсэн эд ангийг солиогүйгээс
3. Механикийг дуудахад ирээгүйгээс
4. Бэхэлгээний болтууд сул байх
5. Лифтийг цэвэрлээгүй бохир байлгаснаас
6. Цахилааны хүчдэл тасрах

Хариу 3

**7. Лифт огт ажиллахгүй байна. Энэ үед автомат хаяад рубильник залгагдахгүй байж болно. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Трансформаторын ороомог буюу хүчний хэлхээнд богино холбоо үүссэн байна
2. Хөдөлгүүрт богино холболт үүссэн байна
3. Удирдлагын палатанд богино холбоо үүссэн байна
4. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд шулуутгагч /ВП1/ ажиллагаагүй байна

Хариу 3

**8. Лифт огт ажиллахгүй байна. Энэ үед автомат хаяад рубильник залгагдахгүй байж болно. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Трансформаторын ороомог буюу хүчний хэлхээнд богино холбоо үүссэн байна
2. Тэжээлийн блокт богино холбоо үүссэн байна
3. Хөдөлгүүрт богино холболт үүссэн байна
4. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд шулуутгагч /ВП1/ ажиллагаагүй байна

Хариу 2

**9. Лифт огт ажиллахгүй байна. Энэ үед автомат хаяад рубильник залгагдахгүй байж болно. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Трансформаторын ороомог буюу хүчний хэлхээнд богино холбоо үүссэн байна
2. Хөдөлгүүрт богино холболт үүссэн байна

**3. Гал хамгаалагч шатсан байна**

4. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд шулуутгагч /ВП1/ ажиллагаагүй байна

Хариу 3

**10. Лифт огт ажиллахгүй байна. Энэ үед автомат хаяад рубильник залгагдахгүй байж болно.**

**Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Трансформаторын ороомог буюу хүчний хэлхээнд богино холбоо үүссэн байна

2. Хөдөлгүүрт богино холболт үүссэн байна

**3. Трансформатор шатсан байна**

4. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд шулуутгагч /ВП1/ ажиллагаагүй байна

Хариу 3

**11. Лифт огт ажиллахгүй байна. Гал хамгаалагч шатаж болно. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. ТС трансформаторын ороомогт богино холбоо үүссэн байна

2. Дамжуулагч утсанд богино холбоо үүссэн байна

**3. Тоормосны ороомог шатсан байна**

Хариу 3

**12. Лифт огт ажиллахгүй байна. Гал хамгаалагч шатаж болно. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. ТС трансформаторын ороомогт богино холбоо үүссэн байна

2. Дамжуулагч утсанд богино холбоо үүссэн байна

**3. Тэжээлийн блок шатсан байна**

Хариу 3

**13. Лифт ажиллаж байгаад автомат хаяад байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хүчний хэлхээнд бэхэлгээний болт суларсан байна

**2. Контактторын бэхэлгээний болт суларсан байна**

Хариу 2

**14. Лифт ажиллаж байгаад автомат хаяад байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хүчний хэлхээнд бэхэлгээний болт суларсан байна

**2. Гал хамгаалагчийн бэхэлгээний болт суларсан байна**

Хариу 2

**15. Лифтийг ажиллуулахад хөдөлгүүр дүнгэнээд эргэхгүй байж байгаад автомат хаях. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Тоормосны татах ороомогт тэжээл очихгүй байх буюу механик гацаанаас болж тоормос ажиллахгүй /тэлэхгүй/ байна

**2. Автоматны контактын хавчих хүч хүрэлцэхгүй байна**

3. Хөдөлгүүрт фаз дутуу ирж байна

4. Лифтийн үндсэн /дээш доош явуулах/ контакторуудын авалцуур авахгүй байх

Хариу 2

**16. Лифтийг ажиллуулахад хөдөлгүүр дүнгэнээд эргэхгүй байж байгаад автомат хаях. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Тоормосны татах ороомогт тэжээл очихгүй байх буюу механик гацаанаас болж тоормос ажиллахгүй /тэлэхгүй/ байна

2. Хөдөлгүүрт фаз дугуу ирж байна
3. Трансформаторын ороомогт богино холбоо байна
4. Лифтийн үндсэн /дээш доош явуулах/ контакторуудын авалцуур авахгүй байх

Хариу 3

**17. Лифтийг ажиллуулахад хөдөлгүүр дүнгэнээд эргэхгүй байж байгаад автомат хаях. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Тоормосны татах ороомогт тэжээл очихгүй байх буюу механик гацаанаас болж тоормос ажиллахгүй /тэлэхгүй/ байна
2. Хөдөлгүүрт фаз дугуу ирж байна
3. Лифтийн үндсэн /дээш доош явуулах/ контакторуудын авалцуур авахгүй байх
4. Трансформатор ажиллахгүй байна

Хариу 4

**18. Лифт залгаатай боловч явахгүй байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хонгилын хаалга бүрэн хаагдаагүй байна
2. Башмак зам төмөр дээр гацчихсан байна
3. Хонгилын хаалганы түгжээний контактын тохиргоо алдагдсан байна
4. Оросын лифтүүдэд бол реле РКД ажилгүй буюу түүний авлцуур бохирдсон байна
5. Ослоос хамгаалах хэрэгслийн аль нэг таслагч дарагдсан байна

Хариу 2

**19. Лифт залгаатай боловч явахгүй байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хонгилын хаалга бүрэн хаагдаагүй байна
2. Хонгилын хаалганы түгжээний контактын тохиргоо алдагдсан байна
3. Оросын лифтүүдэд бол реле РКД ажилгүй буюу түүний авлцуур бохирдсон байна
4. Хурд хязгаарлагч гацчихсан байна
5. Ослоос хамгаалах хэрэгслийн аль нэг таслагч дарагдсан байна

Хариу 4

**20. Лифт залгаатай боловч явахгүй байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хонгилын хаалга бүрэн хаагдаагүй байна
2. Хонгилын хаалганы түгжээний контактын тохиргоо алдагдсан байна
3. Оросын лифтүүдэд бол реле РКД ажилгүй буюу түүний авлцуур бохирдсон байна
4. Ослоос хамгаалах хэрэгслийн аль нэг таслагч дарагдсан байна
5. Даац хязгаарлагч ажилгүй болсон байна

Хариу 5

**21. Хонгилын хаалга онгорхой байхад бүхээг хөдөлгөөнд орж байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд хаалганы хаах реле /РЗД/ ажилгүй байна
2. Хаалганы самбарын тохиргоо алдагдсан байна
3. Хонгил ба бүхээгний хаалганы түгжээний таслагч ажилгүй буюу богино холбогдсон байна

Хариу 2

**22. Хонгилын хаалга онгорхой байхад бүхээг хөдөлгөөнд орж байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Хаалганы ремень сул байна
2. Цахилгаан релены удирдлагатай лифтэнд хаалганы хаах реле /РЗД/ ажилгүй байна

3. Хонгил ба бүхээгний хаалганы түгжээний таслагч ажилгүй буюу богино холбогдсон байна

Хариу 1

23. Хөдөлгүүр зогссоны дараа бүхээг нэг хэсэг газар яваад босго зөрж зогсох. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Тоормосны наклад элэгдсэн, тослогдсон эсвэл тохиргоо алдагдсан байна
2. Бүхээг хэт хурдтай доошилсон байна

Хариу 2

24. Баригч үе үе бариад байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Хурд хязгаарлагчийн пүрш хугарсан буюу суларсан байна
2. Баригчийн татуурга тахийсан байна
3. Зам төмрийн гулгагч /башмак/ элэгдсэн байна

Хариу 2

25. Баригч үе үе бариад байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Хурд хязгаарлагчийн пүрш хугарсан буюу суларсан байна
2. Зам төмрийн гулгагч /башмак/ элэгдсэн байна
3. Баригчийн таслагчийн тохиргоо алдагдсан

Хариу 3

26. Баригч үе үе бариад байх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Хурд хязгаарлагчийн пүрш хугарсан буюу суларсан байна
2. Аажим зогсоох баригч тавих ёстой газар огцом зогсоох баригч тавьсан
3. Зам төмрийн гулгагч /башмак/ элэгдсэн байна

Хариу 2

27. Хөтлүүрийн шкив элэгдэж түүний орчимд төмрийн үүрдэс үзэгдэх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Шкивын ховил элэгдээд ган татлагад хүрсэн байна
2. Шкив хазгай суурилснаас ган татлага шкивны хананд шүргэж байна
3. Ган татлага эрчлээстэй байна
4. Шкивны материалыг буруу сонгосон

Хариу 4

28. Хөтлүүрийн шкив элэгдэж түүний орчимд төмрийн үртэс үзэгдэх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Шкивын ховил элэгдээд ган татлагад хүрсэн байна
2. Шкив хазгай суурилснаас ган татлага шкивны хананд шүргэж байна
3. Шкивны ховил багадсан байна
4. Ган татлага эрчлээстэй байна

Хариу 3

29. Хөтлүүрийн шкив элэгдэж түүний орчимд төмрийн үртэс үзэгдэх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?

1. Шкивын ховил элэгдээд ган татлагад хүрсэн байна
2. Шкивны ховилын налуугийн өнцөг ихэдсэн байна
3. Шкив хазгай суурилснаас ган татлага шкивны хананд шүргэж байна
4. Ган татлага эрчлээстэй байна

Хариу 2

**30. Хөтлүүрийн шкив элэгдэж түүний орчимд төмрийн үртэс үзэгдэх. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Шкивын ховил элэгдээд ган татлагад хүрсэн байна
2. Шкив хазгай суурилснаас ган татлага шкивны хананд шүргэж байна
3. Ган татлага эрчлээстэй байна
4. Ган татлагыг буруу сонгосон байна

Хариу 4

**31. Бүхээг савлах хөдөлгөөнтэй байна. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Гулгагч /Башмак/ элэгдсэн, солих шаардлагатай байна
2. Чиглүүлэгч зам төмрийг тэгш суурилуулж чадаагүйгээс гулгааг завсар ихтэй тавьсан байна
3. Бүхээгний бэхэлгээний болт суларсан

Хариу 3

**32. Бүхээг савлах хөдөлгөөнтэй байна. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Гулгагч /Башмак/ элэгдсэн, солих шаардлагатай байна
2. Гулгаа /башмак/ байхгүй байна
3. Чиглүүлэгч зам төмрийг тэгш суурилуулж чадаагүйгээс гулгааг завсар ихтэй тавьсан байна

Хариу 2

**33. Бүхээг савлах хөдөлгөөнтэй байна. Үүний шалтгаанд юуг илүү бичсэн байна вэ?**

1. Гулгагч /Башмак/ элэгдсэн, солих шаардлагатай байна
2. Чиглүүлэгч зам төмрийг тэгш суурилуулж чадаагүйгээс гулгааг завсар ихтэй тавьсан байна
3. Баригчгүй байна

Хариу 3